

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ЕСДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны дөрөвдүгээр сарын 06-ны 14 цаг 07 минутад эхэлж, 16 цаг 55 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, 2 цаг 48 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах Комиссоос зохион байгуулсан сонгон шалгаруулалтын танилцуулга /Удирдах албан тушаалтанд дүгнэлт гаргах, нээлттэй сонгон шалгаруулалтын дүн, тайлан/	
2	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Шинжлэх ухаан, технологийн бодлогын газрын дарга, Соёл, урлагийн бодлогын газрын дарга зэрэг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2017 оны НСШ/12 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн:</p> <p>1. Мөнхбаярын Мөнхбаатар, Жанчивдоржийн Эрдэнэ нарыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх</p> <p>2. Мөнхбаярын Мөнхбаатарыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор</p>

		<p>баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2017 оны НСШ/13 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн:</p> <p>Түдэвийн Ган-Эрдэнийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Шинжлэх ухаан, технологийн бодлогын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэн, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа удирдлагын газрын дарга, Даатгалын газрын дарга, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга зэрэг албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/32 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Бадамын Батзоригийг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны Захиргаа удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга /Т.Жамбаажамц/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/33 дугаар</p>

		<p>дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Моломжамцын Өлзийбатыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны Даатгалын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга /Т.Жамбаажамц/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/34 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Бямбажавын Ариунааг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга /Т.Жамбаажамц/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Хүний эрхийн Үндэсний комиссын Бодлого, дүн шинжилгээ, хүний эрхийн боловсролын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/35 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Цээхээгийн Адъяахишигийг Хүний эрхийн Үндэсний комиссын Ажлын албаны Бодлого, дүн шинжилгээ, хүний эрхийн боловсролын хэлтсийн</p>

		<p>даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүний эрхийн Үндэсний комиссын Ажлын албаны дарга /Ч.Алтангэрэл/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/36 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Балдандоржийн Алтанцомыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын тэргүүн дэд даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Зам, тээврийн хөгжлийн сайд /Д.Ганбат/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Тэргүүн дэд даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/37 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Чулуунбатын Алтанхуягийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Тэргүүн дэд даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Н.Номтойбаяр/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

7	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “б”, Сонгон шалгаруулах комиссын Д/38 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Хүрэлбаатарын Улам-Өрнөхийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга /Ц.ням-Осор/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
8	<p>Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2017 оны НСШ/20 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн:</p> <p>Чимэдийн Энхбатыг Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэн, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Дархан-Уул аймгийн Засаг дарга /С.Насанбат/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
9	<p>Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо нөхөх мэргэшлийн шалгалтын дүн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл,</p>

	<p>2017 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Дундговь аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 14 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 8 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх2. Энэхүү тогтоолын нэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан гуравдугаар хавсралтад дурдсан нэр бүхий 7 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 6 иргэн, нийт 13 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх3. Тогтоолын 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 13 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь Салбар зөвлөл /О.Чулуунбат/-д үүрэг болгох4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад
--	--

		<p>даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
10	<p>Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2 дахь заалт, 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн батлах Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> - Засаг даргын Тамгын газрын дарга <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга - Ерөнхий аудитор - Цагдаагийн газрын дарга - Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга - Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга - Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга - Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга - Шүүхийн Тамгын газрын дарга - Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын дарга <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> - Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

		<p>2. Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь Салбар зөвлөлийг удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүгнэлт гаргаж нэр дэвшүүлэх, албан тушаалын зэрэг дэв олгох, албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлага, ёс зүй, төрийн албатай холбогдон гарсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Баатарзоригт, Төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг зохион байгуулж, нэр дэвшүүлэх, төрийн албанд анх орох иргэний болон төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлэх, албан хаагчийн сургалт хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг гишүүн С.Цэдэндамбад тус тус зөвлөх</p> <p>3. Төрийн албаны тухай хууль түүнтэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, санаачилагатай ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлд үүрэг болгох</p> <p>4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 20 дахь хэсэг, 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 20 дахь хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” мөн Зөвлөлийн 2015 оны 55 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
11	Төрийн жинхэнэ албан хаагчдад төрийн	Төрийн албаны тухай хуулийн

	захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай	20 дугаар зүйл, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу төрийн захиргааны албан тушаалын тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн саналыг хэлэлцээд, нэр бүхий 13 албан хаагчдад эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв.
--	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА